



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар A/660

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 41 зүйлийн 41.2.2 дахь заалтууд, Эрүүл мэндийн тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Эрүүл мэндийн төвүүдэд нэн шаардлагатай эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багаж, тоног төхөөрөмжийг олгоход 20 000 000 сая төгрөгийн дэмжлэгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Зардалд шаардагдах хорин сая төгрөг /хорин сая/ -ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.13 дахь заалтын "Эх хүүхдийн ээлтэй тусламж үйлчилгээ" төсөл, хөтөлбөрийн зардлаас тооцож олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Уранчимэг/-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА




Б.ДҮГЭРЖАВ

Zax A/660 Ch

02 03266

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар
сарын 15-ны өдрийн А/660 дугаар
захирамжийн хавсралт



СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДЭД НЭН ШААРДЛАГАТАЙ
ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

№	Багаж тоног төхөөрөмжийн нэрс	Тоо ширхэг	Нэг бүрийн дундаж үнэ /мян төг/	Нийт үнэ /мян төг/
1	Нярай хүүхдийн судас тодруулагч /атгадаг, гэрэлтэй-Хятад улс/	16	250 000	4 000 000
2	Хүүхдийн цахилгаан жин –Хятад улс	16	250 000	4 000 000
3	Хүүхдийн тариурын автомат шахуурга	5	2400 000	12 000 000
НИЙТ ДҮН				20 000 000

-oOo-